

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.08.01

№ 15

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1	Хөнгөлөлттэй зээл олгох тухай	Ж.Ганбат	В.Рэнцэндорж Р.Цэнд-Аюуш	Тогтоол 65
2	Төрийн дээд шагналд өргөн мэдүүлэх тухай	В.Алтайбаатар		Тогтоол 66
3	Хөрөнгө зарцуулах тухай	А.Амарзаяа	Г.Соёлоо	Тогтоол 67

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 65

Есөнбулаг сум

Хөнгөлөлттэй зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, “Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор “Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын шаардлага хангасан хавсралтад дурдсан төсөлд хөнгөлөлттэй зээл олгосугай.


2. Шалгарсан төсөлд хөнгөлөлттэй зээл олгох гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь холбогдох хууль журмын дагуу хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай. .

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



01 0000227

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн  
65 дугаар тогтоолын хавсралт



ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ

Д/д	Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	Төслийн нэр	Үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл тоо	Олгох зээлийн хэмжээ /сая төг/
1.	"Солонго дулааны станц" ААТҮГ	"Инженерийн шугам сүлжээ байгуулах"	Хэрэглэгчдийг дулаан хангамжаар хангах	150 000 000

---oOo---



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 67

Есөнбулаг сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 20.1.14 дэх заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ховд аймагт 2019 оны 09 дүгээр сард зохион байгуулагдах Баруун бүсийн нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультаан, ажилтнуудын сургалт семинар, спортын арга хэмжээнд зориулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлаас 14913000 /арван дөрвөн сая өсөн зуун арван гурван мянга/ төгрөгийг гаргаж зарцуулсугай.

2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүсийн арга хэмжээ, зөвлөлдөх уулзалтад оролцох бүрэлдэхүүнийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, амжилттай оролцохыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Амарзаяа)-д үүрэг болгосугай.



ДАРГА  Д.БАТЖАРГАЛ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 66

Есөнбулаг сум

Төрийн дээд шагналд өргөн  
мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн өндөр амжилт гарган, боловсролын салбарт оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр Жамъяаншаравын Дүгэрийг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

2. Төрийн дээд шагналд тодорхойлогдсон Жамъяаншаравын Дүгэрийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба, нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Амарзаяа)-д даалгасугай

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



01 0000224